

МОНГОЛ УЛСЫН ИХ СУРГУУЛЬ
ШИНЖЛЭХ УХААНЫ СУРГУУЛЬ
“МОНГОЛ СУДЛАЛ”

Эрдэм шинжилгээний сэтгүүл

Боть XLVII (597)






DOI: 10.22353/ms20234709







ДӨРВӨЛЖИН БИЧГИЙН ШАНАГАН 'А-ИЙН ТАЛААР ЭРГЭН
ХАРАХ НЬ

Б.Даваасүрэн

Түлхүүр үг: Дөрвөлжин бичиг, төвөд бичиг, санскрит бичиг, тэг морфем, дэвсгэр үсэг, үсэг зүй

Дэлхийн бичиг үсгийн түүхэнд урт эгшиг авиаг бичиг үсэгт тэмдэглэж ирснийг ажиглавал дараах байдлаар тэмдэглэдэг аж.

- Бүтэн үеэр (монгол бичиг  *ага*; дөрвөлжин бичиг  'u)
- Уртатгалын туслах тэмдгээр илэрхийлэх (санскрит  *ā*; соёмбо а: *ā*; тод бичиг  *ā*; Вагиндра бичиг  *ā*)
- Богино эгшгийг давтаж бичих (кирилл *a – aa*; англи *o – oo, e – ee*)
- Чех хэлэнд богино эгшгийн дээд талд *акут* (лат. *acutus*) туслах тэмдэг тавьж, *á, é, í, ý, ó, ú* урт эгшиг тэмдэглэдэг.
- Япон хэлэнд өмнөх үеийн эгшгийг давтаж бичих аргаар урт эгшиг авиаг тэмдэглэдэг. Жишээлбэл: *おば o ba – おばあ o baa, おじ o ji – おじい o jii, ゆき yu ki – ゆうき yuu ki* гэх мэт.

Эдгээр аргаас харвал улс үндэстэн бүр өөрсдийн хэлний онцлог хийгээд цагаан толгойт үсэг бичиг, үет үсэг, санаа бичиг үү гэдгээс шалтгаалж зохих аргыг боловсруулдаг байна. Төвөд хэлэнд урт эгшиг авиа байдаггүй тул урт эгшиг үсгийн тогтолцоо бүхий хэлний үгийг төвөд бичиг үсгээр хэрхэн тэмдэглэх вэ, гэдэг асуудлыг шийдэхдээ төвөд хэлний 30 гийгүүлэгчээс *шанаган а* буюу төвөд хэлний 23 дах үсэг *a chung* үсгээр илэрхийлэхээр сонгож авчээ. Энэхүү 23 дах үсгийн үүргийн талаар бид өмнөх өгүүлэлдээ нэлээд дэлгэрэнгүй жишээ баримттай дурдсан билээ. Тиймээс жишээлбэл, монгол хэлний *хаан* гэдэг үгийг төвөд бичгээр урт *aa* эгшиг үсгийг хадгалж тэмдэглэнэ гэвэл төвөд хэлний *ᠮ ha* үет үсгийн доод талд энэхүү *a chung* үсгийг зүүж  *haan* гэж бичнэ. Өөрөөр хэлбэл, төвөд бичиг үсэг нь үет үсэг учир богино эгшиг үсгийг давтаж бичих аргаар урт эгшгийг тэмдэглэх боломжгүй гэсэн үг юм. Хэрэв эгшиг үсгийн араас шууд эгшиг үсэг бичнэ гэвэл, жишээлбэл, монгол хэлний *хаан, аав, хоол* гэдэг үгийг төвөд бичгээр  гэх мэтээр бичихэд хүрнэ. Яг үүнтэй адил дөрвөлжин бичгээр хоёр талын эгшгийг тэр хэвээр нь угсруулан бичнэ гэвэл  *y-'u* →  *y-u*,  *du-'u-sun* →  *du-*

u-sun гэх мэтээр бичих болно. Орчин цагийн монгол хэлэнд *гуай* хэмээн гиатус дуудаж болдог боловч монгол бичиг ба дөрвөлжин бичигт эгшиг бөөгнөрүүлж бичих боломжгүй учир монгол бичгээр ᠭᠤᠢ гэж дэвсгэрлэж бичдэг нь нэгт, монгол хэлэнд уруулын эгшгийн араас уруулын бус эгшиг ордоггүй авиа зүйн тогтолтой, хоёрт, үсэг зүйн хувьд дэвсгэр *᠔*-тэй андуурагдах тул гэдэс махбодын араас шүд махбод ордоггүй. Тиймээс дөрвөлжин бичиг зохиогдсон цаг үед хоёр эгшгийн дундах *γ/g, b, m* хэдийгээр сугарсан ч хоёр талын эгшиг хараахан ижилсэж амжаагүй учир *a chung* үсгийг хоёр эгшгийг зааглах үүргээр хэрэглэсэн байна. Энэ авиа зүйн онцлог бол зөвхөн монгол хэлээр зогсохгүй ерөөс нийт алтай овгийн хэлнүүд буюу залгамал бүтэцтэй хэлний онцлог бөгөөд үгийн эхэн, дунд, адагт хэзээ ч эгшиг ба гийгүүлэгч бөөгнөрч ордоггүй, хоёр эгшиг угсарч орох тохиолдолд гийгүүлэгч үсгээр, хоёр гийгүүлэгч угсарч орвол эгшиг үсгээр тусгаарладаг авиа зүйн хуультай. Эдүгээ ч орчин цагийн монгол хэлэнд *эмээ+ийн* залгахад *эмээийн* хэмээн эгшиг бөөгнөрөх учир *эмээ+Г+ийн* гэж жийрэг *Г* гийгүүлэгчээр тусгаарладаг. Түрэг хэлэнд мөн адил түр. *pencere* «цонх» + *-e* «-руу, -рүү» → *pencereye*, түр. *ev* «гэр» + *de* «-д, -т» + *-im* «би» → *evdeyim* «би гэрт(ээ) (байна)» эсвэл *araba* «тэрэг, машин» + *lari* «тэдний» + *i* «з.т.я.» → *arabalarını* «тэдний тэргийг, машиныг» гэх мэтээр *у, n* гийгүүлэгч жийрэглэдэг. Монгол хэлний энэ авиа зүйн хуулийн дагуу дөрвөлжин бичигт төвөд бичгийн *a chung* үсгийг хэрэглэхээр тохируулсан аж. Хэрэв дөрвөлжин бичгийн *a chung* үсгээр бие даасан фонемыг тэмдэглэж байсан гэж үзвэл их *ᠠ*-ийн байранд буюу үгийн эхэнд их *ᠠ*-ийн оронд орж болох байсан боловч тийм жишээ дөрвөлжин бичигт огт тохиолддоггүй. Төвд хэлэнд *a chung* тэг бүтээврийн үүрэгтэй буюу уншигддаггүй учир дөрвөлжин бичигт хоёр эгшгийн дунд орсон *γ/g* сугарч гээгдсэнийг тусгах маш оновчтой авиа зүй, үсэг зүйн арга байсан гэж үзэж байна.

Түүнчлэн дөрвөлжин бичигт үгийн эхэнд орсон хэлний урдуурх *i* эгшгийг ᠶᠢᠷᠭᠡᠨ *ir-gen* = ᠶᠢᠷᠭᠡᠨ *'ir-gen*; хэлний дундуурх *u* эгшгийг ᠤᠰᠤ *u-su* = ᠤᠰᠤ *'u-su*; ᠤᠷᠢᠳ *u-ri-d* = ᠤᠷᠢᠳ *'u-ri-d* гэх мэтээр бичсэн байдаг нь *a chung* титэм махбодын үүргээр хэрэглэгдэж байсны баталгаа. Энэ нь мөн л *a chung* тэг бүтээврийн үүрэгтэй буюу уншигддаггүй учир үсэг зүйн хувьд титэм махбодын үүргээр хэрэглэхээр оноосон хэрэг юм.

Түүнчлэн дөрвөлжин бичгийн дурсгалд харь үгийг үсэгчлэн буулгадаг зарчимтай учир *a chung* гадаад үгэнд ордоггүй. Орсон тохиолдолд тэг бүтээвэр байх үүргээ алдана гэсэн үг.

Харин тод, соёмбо, вагиндра бичигт тухайн үеийн богино эгшгийг уртаар дууд гэсэн тэмдгийг дөрвөлжин бичгийн шанаган *ᠠ* *'a* гийгүүлэгчтэй адилтган үзэж болохгүй. Өөрөөр хэлбэл, тод, соёмбо, вагиндра бичигт хэрэглэдэг уртатгалын тэмдэг бол туслах тэмдэг. Соёмбо бичгийг зохиохдоо *ланз ~ ранз* үсгийг үлгэр болгож зохиосон тул *ранз* үсэгт урт эгшиг үсгийг хэрхэн тэмдэглэдэг вэ, тэр зарчмыг авсан болно. Учир нь соёмбо үсэг зохиогдсон цаг үед монгол бичигт урт эгшгийг тэмдэглэдэг ЭГЭ гэсэн үе бүтцийн хоёр талын эгшиг хэдийнээ ижилсэж үүсмэл урт эгшиг үүссэн үе гэдгийг бид мэднэ. Тэгвэл *ранз* бичиг, соёмбо бичиг абугида үет үсгийн тогтолцоотой бичиг үсэг тул урт эгшиг үсгийг уртатгалын тэмдгээр тэмдэглэдэг зарчмыг шууд авсан гэсэн үг. Дөрвөлжин бичиг бол *ранз*, соёмбо бичгийн адил абугида үет үсэг мөн боловч монгол бичгийн зөв бичих зүйг

баримталж бичдэг, нөгөөтээгүүр төвөд хэл урт эгшиггүй хэл юм. Тиймээс дээр дурдсанчлан дөрвөлжин бичигт эгшиг үсгийг ар араас нь бөөгнөрүүлж бичих ямар ч боломжгүйтэй холбоотой. Монгол бичигт мөн адил хоёр эгшиг үсгийг ар араас нь бичих боломжгүй. Тод ба Вагиндра бичгийг монгол бичигт тулгуурлаж зохиосон учир урт эгшиг үсгийг бас л угсруулж бичих боломжгүйгээс үүдэж ранз, соёмбо бичигт урт эгшиг үсгийг тэмдэглэдэг зарчмыг шууд авсан байна.

Монголчууд 1942 оноос хэрэглэж ирсэн оросжин бичгийн тухайд гэвэл дэлхийн бичиг үсгийн системийн дорнод грекийн салбарт багтдаг үсэг бичиг. Европ дахинд XIV зуунаас урт эгшиг үсгийг бичиг үсэгтээ тэмдэглэх шаардлага тулгарснаа богино эгшиг үсгээ давтаж бичих аргаар илэрхийлдэг болсон бөгөөд тэр аргыг оросжин бичиг өвлөж авсан бичиг юм. Жишээлбэл, эст. *sada* [sata] «зуу (тоо)» — *saada* [sa:ta] «илгээ»; англ. *street, sheep, good, foot* г.м.

Үүнээ нэгтгэн хэлбэл, төвөд ба дөрвөлжин бичгийн аль аль нь урт эгшиг үсгийг уртатгалын туслах тэмдгээр илэрхийлдэг абугида үет үсгээс үүссэн хэдий ч төвөд хэлэнд урт эгшиг байдаггүй, тэмдэглэх шаардлагатай бол тэг бүтээврийн үүрэгтэй *шанаган а* буюу *а chung*-аар тэмдэглэдэг. Монгол бичигт урт эгшиг байдаг ч түүнийгээ бүтэн үеэр тэмдэглэдэг зүй тогтолтой учир төвөд хэлний нэгэн адил тэг бүтээврийн үүрэгтэй *а chung*-аар тэмдэглэх бүрэн боломжтой байсан аж.

Ном зүй

- Владимирцов Б.Я. 1989. Сравнительная грамматика монгольского письменного языка и халхасского наречия. М., 432х.
- Санжеев Г.Д. 1977. Лингвистическое введение в изучении истории письменности монгольских народов. У-У., 161 х.
- Рерих Ю.Н. 2001. Тибетский язык. М., 135 х.
- Лувсанвандан Ш. 1967. Дөрвөлжин үсгийн дурсгалын зүйлд эгшигийн урт богиныг ялгасан нь. Хэл зохиол IV боть. Улаанбаатар
- Лувсанвандан Ш. 1967. Орчин цагийн монгол хэлний урт эгшигийн гарлын тухай асуудалд. Хэл зохиол IV боть. Улаанбаатар
- Лувсанвандан Ш. 1975. Монгол дөрвөлжин үсгийн дурсгалын зүйлийг галиглах тухай асуудалд. Хэл зохиол судлал XI боть. Улаанбаатар
- Лувсанвандан Ш. 1980. “Дөрвөлжин үсгийн шанаган 𐰢-ийн тухай асуудалд. Хэл зохиол судлал XIV боть. Улаанбаатар
- Лувсанвандан Ш. 1980. Монгол дөрвөлжин үсгийн их а шанаган а ийн тухай асуудалд. *Studia Mongolica* VI (14) боть. Улаанбаатар
- Поппе Н.Н. 1941. Квадратная письменность. Москва-Ленинград
- Санжеев Г. Д. 1953. Сравнительная грамматика монгольских языков. Москва
- Ууганбаяр М. 2022. Монгол дөрвөлжин бичгийн шанаган *а* үсгийн тухай. Хэл зохиол судлал. Боть XV (47). Улаанбаатар.

Резюме

Данная статья является продолжением об интервокальной согласной буквы འ 'a, именуемая в тибетской грамматике как *a chung*. Затрагиваемая нами проблема была рассмотрена в связи с другими письменными системами как ясное письмо, письмо Вагиндры, а так же с письмом ранджана, которое впоследствии стало не только эталоном многих письменностей, но и некоторые его графические способы выражения букв были приняты другими письменностями. Хотя в тибетском языке отсутствуют долгие гласные, тибетские ученые изобрели способ выражения долготу гласных, например, санскритских слов, путём добавления буквы *a chung* под соответствующими буквами (как подписную букву) и которая в грамматике тибетского языка считается нулевой морфемой.

Именно эта особенность нулевой фонемы *a chung* в тибетской письменности была принята в письме Пагба ламы для выражения отпавшей интервокальных согласных γ/g , *b*, *m* монгольского языка XIII века.